



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/302

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн
төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 48 дугаар зүйлийн 48.2.6, 48.2.7, 48.2.9, Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 278 дугаар тогтоол, Сангийн сайдын 2023 оны "Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай" А/258 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны "Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай" А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр Дайвар бүтээгдэхүүн хагас болон бүрэн боловсруулах тоног төхөөрөмж нийлүүлэх /Цагаан-Уул сум/ гүйцэтгэгч сонгох төсөл арга хэмжээнд ХӨАХААГ/20240102056 дугаартай 124,765,950 (Нэг зуун хорин дөрвөн сая долоон зуун жаран таван мянган есөн зуун тавин) төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Ашид Эрдэнэс" ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. "Ашид Эрдэнэс" ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, барилгын шинэчлэлтийн ажлын үе шатны хяналт хэрэгжүүлэх этгээдтэй гэрээ байгуулах дүгнэх, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэх чиг үүрэг бүхий захиалагчийн төлөөлөгч, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Захиалагчийн төлөөлөгч:

Б.Оюунтуяа

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хөрөнгө
оруулалтын хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд:

Д.Түмэнбаяр

(Аймгийн Цагаан-Уул сумын Засаг
даргын Тамгын газрын дарга)

Н.Алтанчимэг

(Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
хөрөнгийн бүртгэл мэдээлэл хариуцсан
мэргэжилтэн)

О.Болд-Эрдэнэ

("Ашид Эрдэнэс" ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга:

Д.Чинзориг

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

3. Дайвар бүтээгдэхүүн хагас болон бүрэн боловсруулах тоног төхөөрөмж нийлүүлэх /Цагаан-Уул сум/ гүйцэтгэгч сонгох төсөл арга хэмжээнд сонгох гэрээнд заасан

d/A4

6712010972

захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг хангах, барааг (үйлчилгээг) хүлээн авах, гэрээг дүгнэх, санхүүжилтийн гүйцэтгэл баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн тухай ажлын үр дүнг тайлагнах, тайланг хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивт шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг захиалагчийн төлөөлөгч (Б.Оюунтуяа)-д, захиалагч, тендерт оролцогчийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээ дүгнэсэн акт, бараа (үйлчилгээ) хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг хуульд заасан бусад баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон Худалдан авах ажиллагааны газрын архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Даваасамбуу)-д тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР